



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/184

Бор-Өндөр

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222 дугаарыг тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг идэвхтэй хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоог хангах, олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилгын тайлангийн мэдээллийг ард иргэд, олон нийтэд мэдээлж хэвших, нээлттэй хүргэх ажлыг зохион байгуулах дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд зөвлөлийн дарга:

Д.Отгонцэцэг

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Э.Отгонтунгалаг

Байгаль орчны улсын байцаагч

Гишүүд:

С.Эрдэнээ

6 дугаар багийн Засаг дарга

Ш.Болор-Эрдэнэ

Бор-Өндөр Уулын Баяжуулах үйлдвэр

У.Пүрэвжав

"Сентурия Монгу" ХХК-ний Хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлын инженер

2.//

Ч.Болдбаатар

“Жинтайхэ” ХХК-ний Уурхай хариуцсан дарга

Д.Тунгалаг

“Шүхэрт зөгий” ТББ-ын дарга

Э.Энхболд

Иргэний нийгмийн төлөөлөл

Д.Энхбаатар

Иргэний нийгмийн төлөөлөл

2. Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлагын сумын 2018 оны жилийн ажлын төлөвлөгөөг батлуулах, тайлангийн мэдээллийг ард иргэд , олон нийтэд мэдээлж, нээлттэй хүргэх ажлыг зохион байгуулж, ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр танилцуулж ажиллахыг дэд зөвлөлийн дарга /Д.Отгонцэцэг/-т даалгасугай.

ДАРГА



П. ЧИНБАТ